

ТОВЧ ХУРААНГУЙ

Судалгааны нэр: Дууны хөвчийн саажилтын дараах төвөнхийн үйл ажиллагааны алдагдлыг нөхөн сэргээх мэс заслын эмчилгээний үр дүн

Судалгааны ажлын үндэслэл

Дууны хөвчийн саажилт (ДХС) нь төвөнхийн мэдрэлжүүлэлт алдагдсанаас булчинд сөнөрөх өөрчлөлт гарч хөвч хөдөлгөөнгүй болох эмгэг юм.

Дууны хөвчийн нэг талын саажилт (ДХНС)-ын үед аль нэг хөвч хөдөлгөөнгүй болж хөвчүүдийн нийлэмж алдагдсанаар дуу сөөх, дуу авиагүй болох шинж тэмдэг илэрч, цацах, хахах цагаан мөгөөрсөн хоолойд аспираци /бөглөрөл/ үүсгэн уушгины хатгаагаар хүндэрч амьдралын чанарт нөлөөлдөг байна. Харин дууны хөвчийн хоёр талын саажилт (ДХХС)-ын үед хөвчүүд голын, иж голын байрлалд гацаж, нээгдэж чадахгүй болсноор амьсгалахад бэрхшээл үүсч, шуугиантай амьсгалах, амьсгал бачуурснаас богино хугацаанд амь эрсдэх шалтгаан болдог.

ДХС болон төвөнхийн эмгэгүүдийг оношлох, эмчилгээний үр дүнг үнэлэх, хянахад эрүүл хүний дууны хэвийн үзүүлэлтүүдийг тодорхойлох нь онцгой ач холбогдолтой. Иймээс электроглоттографийн шинжилгээгээр монгол хүний дууны хэвийн үзүүлэлтийг тодорхойлох шаардлага урган гарсан.

Манай оронд ДХНС-ын үед дуу авиа сайжруулах үр дүнтэй эмчилгээний арга хомс, ДХХС-ын үед зөвхөн дууны хөвчийг авах мэс заслаар амьсгалын үйл ажиллагааг сэргээдэг. Иймээс бид дууны хөвчийн саажилтын эмчилгээний орчин үеийн аргуудыг нэвтрүүлэн эмчлүүлэгсэдийн амьдралын чанарыг сайжруулах шаардлагатай байгаа нь судалгаа хийх үндэслэл болов.

Судалгааны зорилго

Монгол хүний дууны хэвийн үзүүлэлтийг тодорхойлон, ДХС-ын эмнэл зүй-электрофизиологийн үзүүлэлтүүдийг мэс заслын эмчилгээний үр дүнтэй уялдуулан судлах.

Арга зүй

Судалгааг 2019 оны 6-р сараас 2021 оны 4-р сарын хооронд хийв. Бид дуу авианы эмгэг өөрчлөлтгүй 360 оролцогсодод электроглоттографи (ЭГГ)-ийн шинжилгээ хийж монгол эрүүл хүний дууны хэвийн үзүүлэлтүүдийг тодорхойлов.

Дууны хөвчийн саажилттай эмчлүүлэгчид орчин үеийн мэс заслын эмчилгээг хийж үр дүнг эмнэлзүйд суурьласан тохиолдлын судалгааны загвараар орчин үеийн багаж тоног төхөөрөмж, асуумжийн аргыг ашигласан судалсан.

ДХНС-тай 82 эмчлүүлэгчид дуу үүсгэх үйл ажиллагааг нөхөн сэргээх зорилгоор, өөрийн хүсэлтийг харгалзан тарилга, суулгацын мэс заслын аргаас сонгон хийж, харьцуулан судлав.

ДХХС-тай 24 эмчлүүлэгчид амьсгалын үйл ажиллагааг нөхөн сэргээх зорилгоор дууны хөвчийг оёдлоор гадагшлуулах (ДХОГ) мэс засал хийж уламжлалт аргатай харьцуулан судлав.

Үр дүн

1. Эрэгтэйчүүдийн нас ахих тутам дууны үндсэн давтамж (11.3 гц-ээр), хөг-шуугианы харьцаа (1.3 дб-ээр) нэмэгдэж, дуугарах хамгийн их хугацаа (3.7сек-ээр) статистик ач холбогдолтой буурсан байв. Эмэгтэйчүүдийн нас ахих тутам дууны үндсэн давтамж (13.6 гц-ээр), дуугарах хамгийн их хугацаа (3.7 сек-ээр) буурч, үелзэл (0.32 %-аар), хөг-шуугианы харьцаа (1.3 дб-ээр) нэмэгдсэн байна.

2. ДХНС-ын мэс заслын өмнөх ба дараах үзүүлэлтийн зөрүү үндсэн давтамж (тарилга: эр 7.9 гц, эм 9.1 гц; суулгац: эр 8.9 гц, эм 10.7 гц), хөвчийн нийлэмж (тарилга: 39%, суулгац: 42%), далайц (тарилга: 40%, суулгац: 43%), дууны бэрхшээлийн индекс (тарилга: 57.4 оноо, суулгац: 52.4 оноо), хөг-шуугианы харьцаа (тарилга: 1.5 дб, суулгац: 1.04 дб), дуугарах хамгийн их хугацаа (тарилга: 3.52 сек, суулгац: 3.43 сек) хоёр бүлэгт ялгаатай байв. Видеоларингоскопийн шинжилгээгээр суулгацын бүлэгт дууны хөвчүүд хоорондын завсар үр дүнтэй багасч, видеостробоскопийн шинжилгээгээр үнэлэхэд хөвчийн хэлбэлзлийн үзүүлэлтүүд тарилгын бүлэгт статистик ач холбогдолтой нэмэгдсэн байв.

3. ДХХС-ын үед мэс заслын өмнөх ба дараах үзүүлэлтийн зөрүү хөвч хоорондын завсрын талбай (I бүлэг: 74.3%, II бүлэг: 67.4%), спирометрийн АОАХ (I бүлэг: 30.2%, II бүлэг: 28.7%), ХАГЭ₁ (I бүлэг: 80.2%, II бүлэг: 79.6%), дууны бэрхшээлийн индекс I бүлэгт 2-р зэрэг (41.5 оноо), II бүлэгт 3-р зэрэг (63.4 оноо) болж хоёр бүлэгт статистик ялгаатай нэмэгдсэн байв. Дууны хөвчийг оёдлоор гадагшлуулах мэс засал нь мэс заслын шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэхэд эмчлүүлэгчид аюулгүй, хөнөөл багатай мэс засал болох нь тогтоогдов.

Дүгнэлт

1. Насанд хүрсэн монгол эрүүл хүний дууны үндсэн давтамж, дуугарах хамгийн их хугацаа нь нас болон хүйсээр ялгаатай ба хөг-шуугианы харьцаа нь наснаас, үелзэл нь зөвхөн эмэгтэйчүүдийн наснаас хамааран өөрчлөгдөж байв.
2. Дууны хөвчийн суулгацын мэс засал нь хөвчийн нийлэмжийг сайжруулан дууг чангаруулж, тарилга нь дууны уянгалаг байдлыг хадгалан эмчлүүлэгчийн амьдралын чанарыг богино хугацаанд сайжруулж байна.
3. Дууны хөвчийг оёдлоор гадагшлуулах мэс засал нь төвөнхийн анатомийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй, цагаан мөгөөрсөн хоолойн гуурс тахихгүйгээр амьсгалын үйл ажиллагааг тогтвортой сэргээхийн зэрэгцээ дууны шинж төрх, чанарыг хадгалдаг давуу талтай байв.

Түлхүүр үг: дууны хэвийн үзүүлэлт, дууны хөвчийн саажилт, дууны хөвчийн тарилга, дууны хөвчийн суулгац, дууны хөвчийг оёдлоор гадагшлуулах мэс засал